



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 493

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.4, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гадаадын иргэн, харьяатын газрын Баруун бүс дэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Говь-Алтай аймгийн Онцгой байдлын газрын улсын байцаагчийн 2016 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар дүгнэлтээр тогтоогдсон, нийт 15,000,000.00 (арван таван сая) төгрөгийн балансын үнэ, 8,327,381.22 (найман сая гурван зуун хорин долоон мянга гурван зуун наян нэгэн төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133006000
26-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 10 дугаар сарын 17 өдрийн
175 дугаар тогтоолын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН БАРУУН БУС ДЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ (барилга)

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон, бүртгэсэн он	Хэм жиж нэгж	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Бургастайн боомтын барилга (Говь-Алтай аймгийн Алтай сум)	2009/2018	м2	60	15,000,000.00	8,327,381.22	6,672,618.78
	Нийт дүн				15,000,000.00	8,327,381.22	6,672,618.78